



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум

Утас: 70592439, 70592208, 70593208

И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2020.07.30

№

130

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Эрдэнэдалай сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Эрдэнэдалай сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**


Эрдэнэдалай сумын Ардчилсан намын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

0012020220

Эрдэнэдалай сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / 5.. хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Эрдэнэдалай сумын сонгуулийн хэсгийн хороонд. Хавсралт 5. . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

Эрдэнэдалай сумын Ардчилсан Намын Хорооны  
2020 оны 06 дугаар сарын 22 -ний өдрийн  
10 дугаар хурлаар хэлэлцэж батлав



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

---

2020 он

## НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД

Засаглалын чадварлаг, тогтвортой байдлыг хангаж, “Шилэн засаглал”-ын бодлого хэрэгжүүлнэ.

### 1. Хууль эрх зүйн хүрээнд:

- 1.1 Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллаж орон нутагт нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг батлан гаргахад иргэдийн саналыг бодит байдлаар тусгах
- 1.2 Багийн иргэдийн нийтийн хурлыг чанаржуулж аливаа шийдвэрт иргэдийн саналыг тусгадаг болох
- 1.3 Орон нутагт зохион байгуулагдаж байгаа болон бусад цаг үеийн асуудлаарх мэдээ мэдээллийг цахим технологи /үүрэн холбооны утас, олон нийтийн сүлжээ, орон нутгийн “АСА” цогцолбор гм/ ашиглан иргэдэд хүргэх “Цахим хөтөч” ажиллуулна.
- 1.4 Орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчин ялангуяа эрүүл мэндийн салбарыг боловсон хүчнээр бүрэн хангана.
- 1.5 Иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй хүргэхэд анхаарч нотариатчтай болно.
- 1.6 Төрийн албан хаагчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, төрийн албыг хууль бус томилгоогүй болгоно.
- 1.7 Сумдтай видео хурал, сургалт хийх ажлыг зохион байгуулах, төрийн албаны шуурхай байдлыг ханган ажиллах
- 1.8 Хүн амыг өсгөх, ирж ажиллаж буй залуу боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах, амьдруулахад чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэн, шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалд судалгаа дүгнэлт хийж ажиллана
- 1.9 Нутгийн захиргааны байгууллагаас бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэн төр иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны түншлэлийг бий болгоно.

## ХОЁР. НИЙГМИЙН ХҮРЭЭНД

Нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлогыг орон нутагтаа хэрэгжүүлж, зорилтот бүлгийн иргэдээ дэмжинэ.

### 2. Эрүүл мэнд:

- ✓ Иргэдийг эрүүл амьдралын зан үйлд сургах төрөл бүрийн сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.
- ✓ сум дундын эмнэлгийг боловсон хүчнээр хангах ажлыг орон нутгийн хэмжээнд дэмжиж ажиллана.
- ✓ Эрүүл мэндийн байгууллагаас иргэд үйлчилгээ авахад хүнд сурталгүй болгож “Цахим үйлчилгээг” нэвтрүүлнэ.
- ✓ Авто парк шинэчлэлийг үе шаттай хийж сумын төвийн дуудлагын авто машинтай болгоно
- ✓ Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны цалин урамшууллыг хөдөлмөрийн үнэлэмж, ажлын ачаалалд нийцүүлэн орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.
- ✓ Эм эргэлтийн сангийн үйл ажиллагааг тогтмолжуулж зайлшгүй шаардлагатай эм хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, ард иргэдэд олон улсын стандартад нийцсэн эм, хэрэгслээр үйлчилнэ.
- ✓ Эмчилгээ оношилгооны тоног төхөөрөмжөөр хангана.





Бэлчээрээ хамгаалах бодлого боловсруулж, олон наст болон бэлчээрийн ургамал тариалах, хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, байгалийн тэнцвэрт байдлыг зохицуулдаг зарим төрлийн ан амьтныг хамгаалах бодлого боловсруулан тэдгээрийг агнахыг хориглох шийдвэр гаргаж орон нутагт хэрэгжүүлнэ.

**Дэд бүтэц:**

Нийтийн халуун усны үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**ЭРДЭНЭДАЛАЙ НУТАГ МИНЬ ҮҮРД МАНДАН БАДРАГ**

Мөрийн хөтөлбөр бэлтгэсэн: Ардчилсан намын Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын хороо-г төлөөлж

Нам /эвсэл/-ын нэр

(ТЭМ ДЭГ) Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Ардчилсан намын дарга -ыг төлөөлж

Овог нэр /Бямбаагийн Лхагвамандал/



2020 оны 06 дугаар сарын 22

16:00 цаг

